



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Г
Эмнэлзүйн удирдамж, хөтөч боловсруулах
журам батлах тухай

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн 8, 36, 37 дугаар зүйл, Засгийн газрын 2005 оны 72 дугаар тогтоогоор батлагдсан “Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор **ТУШААХ** нь.

1. “Эмнэлзүйн удирдамж, хөтөч боловсруулах журам”-ыг нэгдүгээр, “Эмнэлзүйн удирдамж боловсруулах загвар”-ыг хоёрдугаар, “Эмнэлзүйн хөтөч боловсруулах загвар”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Шинээр боловсруулах, шинэчлэх шаардлагатай эмнэлзүйн удирдамж, хөтчийн жагсаалтыг гаргаж, жил бүр батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, зохицуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Мөнхбат/-д даалгасугай.
3. Эмнэлзүйн удирдамж, хөтөч боловсруулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга /Д.Дамдиндорж/, төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бусийн оношилгоо эмчилгээний төвийн дарга захирал нарт; хамтран ажилладаг олон улсын болон хамтын ажиллагаатай байгууллагуудад санал тавьж техникийн болон санхүүгийн дэмжлэг авах боломжийг судалж шийдвэрлэхийг Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга /Б.Янжмаа/ нарт тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2011 оны 245 дугаар тушаалыг хүчингүй болгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дарга /Ч.Бат-Эрдэнэ/-д даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Хатанбаатар/-д үүрэг болгосугай.

САЙД

Н.УДВАЛ

002123

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дүгээр
сарын 10 өдрийн 174 дугаарт тушаалын нэгдүгээр
хавсралт

ЭМНЭЛЗҮЙН УДИРДАМЖ, ХӨТӨЧ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эмнэлзүйн удирдамж, хөтчийг боловсруулахад энэхүү журмыг мөрдөж ажиллана.
- 1.2. Эмнэлзүйн удирдамж, хөтчийг шинээр боловсруулах, шинэчлэхдээ оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан, олон улсын жишигт нийцсэн, шинэлэг арга, туршлагад үндэслэн боловсруулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.3. **Эмнэлзүйн удирдамж** гэдэг нь өвөрмөц нөхцөл байдалд тохирсон эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний талаар шийдвэр гаргахад эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгч/ өвчтөнд туслах зорилгоор боловсруулсан нэгдмэл мэдээлэл юм.
- 1.4. **Эмнэлзүйн хөтөч** гэдэг нь үйлчлүүлэгч/ өвчтөнд үзүүлсэн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээний явцад авах бүх арга хэмжээг шат дараалан заасан, баталгаажуулан тэмдэглэх, хянах хэвлэмэл маягт юм. Эмнэлзүйн хөтчийн ач холбогдол:
 - 1.4.1. Үйлчлүүлэгч/ өвчтөнд тусlamж, үйлчилгээний явцын талаар мэдээлэл өгөх,
 - 1.4.2. Тусlamж, үйлчилгээний тэгш байдал сайжрах,
 - 1.4.3. Тусlamж, үйлчилгээ доголдох эрсдэл буурч, чанар тасралтгүй сайжрах,
 - 1.4.4. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн хоорондын харилцаа, ажлыг уялдаа сайжрах, шинэ эмч эмнэлгийн мэргэжилтэн мэргэжлийн баримжаа олох ажлын байранд суралцах,
 - 1.4.5. Эмчилгээ үйлчилгээнд урьдчилан төлөвлөсөн үр дүн гараагүй байгаа дохиог эрт мэдэх,
 - 1.4.6. Тусlamж, үйлчилгээний чанарыг өөрөө үнэлэх, дотоодын болон хөндлөнгийн хяналт тавихад хялбар болох,
 - 1.4.7. Тусlamж, үйлчилгээнд цахим бүртгэл нэвтрүүлэх суурь бий болох,

Хоёр. Эмнэлзүйн удирдамж, хөтөч боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн яамны Оношилгоо, эмчилгээний технологийн хэлтэс нь эмнэлзүйн удирдамж, хөтөч боловсруулах ажлыг ерөнхий удирдлага, арга зүйгээр хангаж, боловсруулсан төсөлд Эрүүл мэндийн яамны газар, хэлтсүүд, мэргэжлийн салбар зөвлөл, холбогдох байгууллагын саналыг тусган, Эрүүл мэндийн сайдын шаалаар батлуулна.

2.2. Эмнэлзүйн удирдамж, хөтчийн төслийг төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн салбар зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг, холбоод болон томилогдсон ажлын хэсгүүд боловсруулна.

2.3. Эмнэлзүйн удирдамж, хөтчийг боловсруулахдаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас батлагдсан болон олон улсын хэмжээнд нотлогдсон удирдамж, стандартыг суурь болгож ашиглана.

2.4. Өвчний хэлбэр, өвчтөний биеийн байдал, эмчилгээний онцлогоос хамаарах оношилгоо, эмчилгээний зайлшгүй хийж тусlamж, үйлчилгээ, гүйцэтгэх ажилбар, гардан үйлдэл, зөвлөгөөг эмнэлзүйн удирдамж, хөтчөнд тусгана.

2.5. Оношилгоо, эмчилгээ, сэргээн засах, хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийг тодорхой нарийвчлан зааж, эм, био бэлдмэлүүдийг олон улсын нэршлээр бичнэ.

2.6. Эмнэлзүйн удирдамжид ашигласан, ишлэл авсан материал, баримт бичгийн жагсаалтыг хавсаргана.

ооОоо

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дүгээр
сарын 10 өдрийн 174 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

197

ЭМНЭЛЗҮЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАХ ЗАГВАР

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ
2. ӨМНӨХ ҮГ
3. ОРШИЛ

A. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

- A.1. Онош эсвэл хамшинж
- A.2. Өвчний код (Өвчний олон улсын - 10 ангилаал)
- A.3. Удирдамжийн хэрэглэгчид
- A.4. Удирдамжийн зорилтууд
- A.5. Удирдамж боловсруулсан он
- A.6. Шинэчлэн засах хугацаа
- A.7. Удирдамж боловсруулахад оролцсон байгууллага, хүмүүсийн нэрс, хаяг
- A.8. Нэр томьёо, тодорхойлолт, эх сурвалж
- A.9. Тархвар зүйн мэдээлэл
- A.9.1 Үндсэн ойлголт

B. ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ДЭС ДАРААЛАЛ (АЛГОРИТМ)


Эрт илрүүлэлтийн дэс дараалал

- B.1. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээ
- B.2. Лабораторийн шинжилгээний хариу хэвийн бус гарсан үеийн алгоритм
- B.3. Багажийн шинжилгээний хариу хэвийн бус гарсан үеийн алгоритм
- B.4. Эмчилгээний алгоритм
- B.5. Үйлчлүүлэгчийг дараагийн шатны эмчид илгээх зарчим

B. ҮЙЛДЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АРГАЧЛАЛ

- B.1. Өвчний олон улсын 10-р ангилаал (ӨОҮ-ын 10-р ангилаал)
- B.2. Эрсдэлт хүчин зүйлс
- B.3. Эрүүл мэндийн боловсрол
- B.4. Эрт илрүүлэлт
 - B.4.1. Эрүүл мэндийн тогтолцооны шатлал бүрд эрт илрүүлэлт зохион байгуулах
 - B.4.2. Эрт илрүүлэлтийн өмнөх зөвлөгөө
 - B.4.3. Зорилтот бүлэг

- B.4.4 Эрт илрүүлэлт хийх арга техник
- B.4.5 Шинжилгээний хариу эерэг гарсан өвчтөнийг хянах аргазүй
- B.5. Эмгэг онош батлагдсан үеийн оношилгоо, эмчилгээ
- B.5.1 Зовиур, эмнэлзүйн шинж
- B.5.2 Ерөнхий ба бодит үзлэг, багажийн шинжилгээ
- B.5.2.1 Дурдатгал (анамнез)
- B.5.2.2 Бодит үзлэг
- B.5.2.3 Эрэмбэлэн ангилалт, яаралтай тусlamж үзүүлэх шалгуур;
- B.5.2.4 Лабораторийн шинжилгээнүүд
- B.5.2.5 Багажийн шинжилгээнүүд
- B.5.2.6 Оношилгооны шалгуур
- B.5.2.7 Ялган оношлогоо
- B.5.3 Өвчтөнг илгээх шалгуур, эмчлэх заалт
- B.5.3.1 Эмчилгээ /эмийн эмчилгээнд эмийн сонголт тун хэмжээ, тун хоорондын зайд, эмчилгээ үргэлжлэх хугацаа, анхаарах заалтууд; мэс заслын эмчилгээнд- заалт, нөхцөл, бэлтгэл, арга техник, мэс заслын өмнө, явавд болон дараа тавих хяналт; эмийн бус эмчилгээ- заалт, эмчилгээ үргэлжлэх хугацаа, анхаарах заалтууд/;




B.5.4 Хяналт

- B.5.4.1 Хяналт ба үнэлгээ

ХАВСРАЛТУУД

НОМ ЗҮЙ

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 дүгээр
сарын 10 өдрийн 114 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт



ЭМНЭЛЗҮЙН ХӨТӨЧ БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Эмнэлзүйн хөтчийн бүрэлдэхүүн хэсэг:
 - 1.1.1. Үйлчлүүлэгч/ өвчтөний иргэний бүтгэлийн мэдээлэл,
 - 1.1.2. Үйлчлүүлэгч/ өвчтөнөөс зөвшөөрөл авах хэсэг,
 - 1.1.3. Өвчний түүх, тусlamж үйлчилгээний хэрэгцээ (зовиур, шаналгаа),
 - 1.1.4. Үйлчлүүлэгч/ өвчтөнд үзүүлэх тусlamж, үйлчилгээний явц авах арга хэмжээний шатлал, жагсаалт,
 - 1.1.5. Горимоос гажсан тухай тэмдэглэлийн хэсэг /хэвийн үзүүлэлтүүдийг тоочих, эсвэл дүрслэл, графикаар тэмдэглэхээр байж болно/,
 - 1.1.6. Бусад тэмдэглээний хэсэг,
 - 1.1.7. Тусlamж, үйлчилгээ үзүүлсэн огноо, цаг хугацааг тэмдэглэх хэсэг,
 - 1.1.8. Тусlamж, үйлчилгээ үзүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний гарын үсэг.
- 1.2. Тусlamж, үйлчилгээн үзүүлэх явцад авах арга хэмжээг тодорхой бичнэ.
- 1.3. Эрсдэл ихтэй ажилбар, арга хэмжээ, мөн туршлага багатай эмч, эмнэлгийн мэргэжилтний түгээмэл гаргадаг алдаатай холбоотой зааварчилгааг тодорхой өгнө.

ТӨГСӨВ.